



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар 12

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.3 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арвангурвдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. “Говийн дэвшил” Хязгаарлагдмал Хариуцлагатай Компаниас Өндөршил сумын Засаг даргын Тамгын газарт үнэ төлбөргүй шилжүүлж буй 71 мкв талбай бүхий Халуун усны барилгыг 37,000,000 /гучин долоон сая/ төгрөгөөр үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Э.Амгаланжаргал)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Үл хөдлөх хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх ажлыг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;


2.2 Тогтоолын биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  СОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн
12 дугаар тогтоолын хавсралт



Өндөршил сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэх барилга

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Биет хэмжээ	Тоо ширхэг	Бүртгэлд тусгах үнэ	Хандивлагч байгууллага
1	Халуун усны барилга	мкв	71	1	37,000,000	"Говийн дэвшил" ХХК
Нийт				1	37,000,000 /Гучин долоон сая/ төгрөг	